БАТЛАВ
“ТОХИЖИЛТ ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-
ЫН ЗАХИРАЛ Б.БАТЖАРГАЛ
2024 оны 04 дүгээр сарын 17

9021080947
5680174 СБТ15015

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН**
**“ТОХИЖИЛТ ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-т ШААРДЛАГАТАЙ ДУЛААНЫ УЛИРЛЫН АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**2024 оны 04 дугаар сарын 17** **Улаанбаатар хот**

Дулаан улирлын ажлын тусгай хувцас нийлүүлэх үйлдвэр, аж ахуйн нэгжүүд дараах стандартыг дагаж мөрдөнө.
Энэ стандартад дараах хүчин төгөлдөр мөрдөж буй стандартуудыг ишлэл болгов. Иш татсан стандартууд дахин хянагдаж өөрчлөгдвөл хамгийн сүүлийн хувилбар эсвэл доорх стандартуудтай дүйцхүйц стандарт мөрдөнө.
Үүнд:
- MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас - ерөнхий шаардлага
- ISO 317:1995 Машинаар хуурайгаар нь цэвэрлэх үед хэмжээний өөрчлөлтийг тогтоох
- ISO 3635 Хувцасны хэмжээний тэмдэглэгээ-хэмжээг тодорхойлох ба авах
- ISO 3758 Нэхмэл бүтээгдэхүүн -хэрэглэгчдэд зориулсан тэмдгийг шошгонд кодлох
- ISO-9237 Агаар нэвтрүүлэлт, агаарын ээлхүүн, агаарын хэмжээ
- ISO 12947-2 Элэгдэл тэсвэрлэлт
- MNS ISO 1835 -3:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. 1м2 -ийн жин тодорхойлох арга
- MNS ISO 1835 -4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга
- MNS ISO 1835-5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга
- MNS ISO 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац суналт
- MNS ISO 1835-7:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тодорхойлох арга
- MNS ISO 1835 -9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга
- MNS ISO 1835 -13:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Үрэлт тэсвэрлэлт тодорхойлох арга MNS ISO 4010:97 Цэвэр ба хагас ноосон ээрмэл даавуу. Ноосны агуулгыг тодорхойлох арга
- MNS ISO 4072 : 1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг угаалгад тодорхойлох арга
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хуурай нойтон байдал үрэлтэд тодорхойлох арга
- MNS ISO 4073:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хими цэвэрлэгээнд тодорхойлох арга

ТОДОРХОЙЛОЛТ,ХИЙЦЛЭЛ

1.1. Ажилчдын хувцас
Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна.
1.1.1.Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас - ерөнхий шаардлага MNS 13688:2000” Монгол улсын стандартын шаардлагыг хангасан байх;
1.1.3.Бат бөх хийгдсэн, эдийн засгийн үр ашигтай байх;
1.1.4.Хувцасны материал нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан байх;

1.1.5.Хувцасны материал, ширхэгтийн бүрэлдэхүүн нь байгалийн ширхэгтийн агууламж 35%-иас багагүй, синтетик ширхэгтийн агууламж 65%-иас багагүй агаар нэвтрүүлэлт 20дм3/м2
-с ихгүй байх
1.1.6.Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх;
1.1.7.Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх;
1.1.8.Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх;
1.1.9.Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүний ая тухыг хангах ба биеийн хүчний ачааллыг багасгахын тулд бололцооны хирээр бага байх;
1.2. Ажлын хувцсанд тавих нэмэлт шаардлага
1.2.1.Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага хангасан байх
1.2.2 Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх;
1.2.3 Ус,тос, масло нэвтрүүлэхгүй байх;
1.2.4. Хөдөлгөөн хийхэд саадгүй. Биед дээд зэргээр таардаг байх;
1.2.5. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй байх;
1.2.6. Хүний биед харшлахгүй байх;
1.2.7. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас, өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байх;
1.2.8. Өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байх;
1.2.9. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байх;
1.2.10. Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх;
1.2.11. Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байх;
1.2.12. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байх;
Зураг 1: Дулааны улирлын ажлын цамцны харагдах байдал


Урдаас харагдах байдал


Ардаас харагдах байдал



Ажилчдын хувцас хийцлэл /Цамц/
1. Гарын чөлөөт хөдөлгөөнийг хангах оруулга
2. Энгэрийн дээд хөндлөн оруулгатай. Оруулга нь /гэрэл ойлгогчтой/ саарал өнгөтэй.
3. Залгаа ханцуйтай, ханцуйны манжетка нь төмөр кнопон товчтой байна.
4. Цамц нь далд цахилгаантай. Дардаг даравчтай байна. Даравч нь төмөр кнопон товчоор тогтдог байна.
5. Энгэрт цахилгаантай халаас, Өмдний ташаанд зураг дээрхтэй адил халаастай байна.
6. Цамцны ханцуй нь ажил гүйцэтгэх үед хөдөлгөөнд саад учруулахааргүй байх ба далны хэсэгт давхар оруулгатай байна.
7. Цамцны ар тал нь захны залгаснаас доош 18 см орчимд, урд тал нь мөрний залгааснаас энгэрийн халаас хүртэл 5 см өргөнтэй саарал өнгийн гэрэл ойлгогчтой байна. Ажилчдын хувцасны оруулга нь зурагт харагдаж байгаа шиг улбар шар өнгөтэй байна. Ханцуй болон бусад хэсэг нь зурагт харагдаж байгаа шиг цэнхэр өнгөтэй байна.
8. Баруун гарын бугалга хэсэгт гэрэл ойлгогчийн дээр компаний лого байрлана.
9. Цамцны ар талд захны залгааснаас доош гэрэл ойлгогч хүртэлх зайнд Сонгинохайрхан дүүргийн "Тохижилт Цэвэрлэгээ үйлчилгээ" ОНӨААТҮГ
гэж цэнхэр өнгөөр 3.0 см өндөртэй үсгээр бичнэ. Үсэгний өргөн 0,5 см-с ихгүй байна.
10. Сугандаа агааржуулалттай байна.

Өмд нь дараах хийцүүдийг тусгасан байна. 2-р зурагт үзүүлэв.
1. Өвдөгний хэсэгт давхарлагатай, өвдөгөнд хуниастай байх.
2. Өвдөгний доод хэсгээр цацруулагчтай
3. Арын суудлын хэсэгт давхарлагатай
4. Ташааны хэсэгт орсон халаастай Хажуу талдаа халаастай, хаалаасны ирмэг хэсгээр улбар шар өнгийн оруулгатай, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой
5. Хажуу талд тагтай ээлхүүнтэй халаастай
Тендерт оролцогч нь тендер нээхээс өмнө ажлын хувцасны загвар болгож нэг хувцас ирүүлнэ.



Өмдний харагдах байдал



ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ НЯГТЛАН Г.ҮҮРИЙНТУЯА
БОЛОВСРУУЛСАН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Ж.АМАРСАНАА

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

| № | Барааны нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж, тун | Барааг хүргэх эцсийн цэг | Бараа нийлүүлэх хугацаа | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (Эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаaa |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | ДУЛААНЫ УЛИРЛЫН АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС | 289 | хос | Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, Агар гудамж, 38/г байр, 203 тоот | 2024.05 сараас 2024 оны 12 сарын 31 хүртэл) Жич: нийлүүлэгч шалгарч гэрээ байгуулагдсанаас хойш гэрээний хуваарийн дагуу татан авалтыг зохион байгуулна. | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
## "ТОХИЖИЛТ ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ" ОНӨААТҮГ-т ШААРДЛАГАТАЙ
## ДУЛААНЫ УЛИРЛЫН АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС ХУДАЛДАН АВАХ ТӨСӨВТ ӨРТӨГ

(Монгол төгрөгөөр)

| № | Барааны нэр | Нэгж үнэ | Тоо ширхэг | Нийт |
|---|---|---|---|---|
| 1. | ДУЛААНЫ УЛИРЛЫН АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС | 100,000 | 289 | 28,900,000 |
| 2 | Нийт төсөвт өртөг | | | 28,900,000 ₮ |

ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ НЯГТЛАН Г.ҮҮРИЙНТУЯА
БОЛОВСРУУЛСАН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Ж.АМАРСАНАА

Сонгинохайрхан дүүргийн Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын тендер шалгаруулалт зохион байгуулах бараа тус бүрийн төсөвт өртөг

(Монгол төгрөгөөр)

| д/д | Тендер шалгаруулалтаар худалдан авах барааны нэр | Хэмжих нэгж | Нийт тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт төсөвт өртөг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дулааны улирлын ажлын тусгай хувцас | Хос /өмд,цамц/ | 289 | 100,000 | 28,900,000 |
| 2 | Хог тээврийн автомашины дугуй | Ширхэг | 162 | Загвар бүр өөр үнэтэй | 108,600,000 |
| 3 | Зөөврийн хогны сав | Ширхэг | 60 | 220,000 | 13,200,000 |
| 4 | Дэрсэн шүүр | Ширхэг | 5,400 | 13,500 | 72,900,000 |
| 5 | Хог тээврийн автомашины сэлбэг, хэрэгсэл | Ширхэг, ком | 108 | Сэлбэг, хэрэгсэл тус бүр өөр үнэтэй | 20,775,000 |
| 6 | Хог тээврийн автомашины тос, масло | Литр, кг | 1,902 | Тос, масло тус бүр өөр үнэтэй | 16,806,000 |
| 7 | Хангамжийн материал | Ширхэг, хос | 20,430 | Хангамжийн материал тус бүр өөр үнэтэй | 81,610,000 |
| 8 | Дизель түлш | литр | 380,000 | 3590 | 1,364,200,000 |
|  | АИ-92 автобензин |  | 5,500 | 2390 | 13,145,000 |
|  | Нийт төсөвт өртөг |  |  |  | 1,720,136,000 |

ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ НЯГТЛАН Г.ҮҮРИЙНТУЯА
БОЛОВСРУУЛСАН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Ж.АМАРСАНАА